

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ:

“ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ  
ДЭМЖИХ САН”-ИЙН ГҮЙЦЭТГЭХ

ЗАХИРАЛ



В.ҮНЭНБАТ

ГҮЙЦЭТГЭГЧ:

“МГБИ”ХХК-НИЙ ЗАХИРАЛ



Л.БАТТУВШИН

**ХӨТӨЛ САЛБАРТ ҮРИЙН ХЭВТЭЭ АГУУЛАХ БАРИХ, ТҮЛХҮҮР  
ГАРДУУЛАХ НӨХЦӨЛТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭ**

Дугаар № АҮ/2018/70

2018 оны 07 дугаар сарын 10

Улаанбаатар хот

**Нэг талаас:** Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3 хороо Дулааны цахилгаан станцын баруун талд Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сан (цаашид “захиалагч” гэх),

**Нөгөө талаас:** НЦ91083056 тоот регистрийн дугаартай Лочингалсан овогтой Баттувшин захиралтай Улаанбаатар хот Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 216, 201 тоотод байрлах 9011182075 тоот улсын бүртгэлийн дугаартай, регистрийн 5283981 /гэрчилгээний/ дугаартай “МГБИ”ХХК (цаашид “гүйцэтгэгч” гэх) Хөтөл салбарт үрийн хэвтээ агуулах барих, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын талаар дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн “Хөтөл салбарт үрийн хэвтээ агуулах барих, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажил”-ыг гүйцэтгэх-г (цаашид “Ажил” гэх) 495,453,550 (Дөрвөн зуун ерэн таван сая дөрвөн зуун тавин гурван мянга таван зуун тавин) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь ажлын гүйцэтгэлийг 495,453,550 (Дөрвөн зуун ерэн таван сая дөрвөн зуун тавин гурван мянга таван зуун тавин) төгрөгийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь гэрээний даалгаварын дагуу Хөтөл салбарт үрийн агуулах барих, түлхүүр гардуулах нөхцөлтэй ажлын гүйцэтгэлийг 2018 оны 09 дугаар сарын 01 –ны өдрийн дотор хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Бусад шаардлагатай баримт бичиг ;
  - Үнийн санал
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;
  - Техникийн тодорхойлолт;
  - Санхүүжилтийн хуваарь
6. Гүйцэтгэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Ажил гүйцэтгэх гэрээний хугацааг захиалагч зөвшөөрсөн тохиолдолд нэг удаа сунгаж болох ба гүйцэтгэгч нь үрийн хэвтээ агуулахыг стандартад нийцүүлж, тоног төхөөрөмжийн туршилт тохируулагыг бүрэн хийж үрийн улаан буудай хүлээн авахад бэлэн болгож комисст хүлээлгэн өгнө.
9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-ийн

Хангамж борлуулалтын хэлтсийн дарга

Хуулийн эрх зүйн хэлтсийн дарга

Санхүү бүртгэл, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо,  
3 дугаар Дулааны цахилгаан станцын баруун талд  
Утас: 51262482

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МГБИ” ХХК-НИЙ ЗАХИРАЛ



Л.БАТТУВШИН

Гүйцэтгэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо,  
Чингисийн өргөн чөлөө 216, 201 тоотод  
байрлах

Утас: 99142974

Капитрон банк: 3026049999

**Гэрээний тусгай нөхцөл**

ГЕН 1.1 (а)	Маргаан шийдвэрлэгч бол: <i>[Нэр, хаяг, утас ба факсын дугаар]</i>
ГЕН 1.1 (ё)	Гүйцэтгэгч бол: <i>[Нэр, хаяг, утас ба факсын дугаар]</i>
ГЕН 1.1 (з)	Гүйцэтгэгчийн төлөөлөгч бол: <i>[Нэр, хаяг, утас ба факсын дугаар]</i>
ГЕН (и)	Гарал үүслийн улс бол: Тендерийн баримт бичгийн Бараа, үйлчилгээ ба Ажил нийлүүлэх худалдан авалтанд сонгогдох эрх бүхий улсууд, нутаг дэвсгэрүүд гэсэн хэсэгт заасан бүх улс орнууд, нутаг дэвсгэр.
ГЕН 1.1 (м)	Захиалагч бол: <i>[Нэр, хаяг, утас ба факсын дугаар]</i>
ГЕН 1.1 (ү)	Төслийн менежер бол: <i>[Нэр, хаяг, утас ба факсын дугаар]</i>
ГЕН 1.1 (ч)	Дуусгавар болгох хугацаа бол: 2018 оны 09 сарын 01-ний өдөр.
ГЕН 3.1.1	Давуу эрхтэй хэл бол: Монгол хэл
ГЕН 3.1.2	Харилцах хэл бол : Монгол
ГЕН 4.1	<p>Захиалагчтай албан бичиг солилцох хаяг:</p> <p>Хэнд: ХХААХҮЯ-ны ТЭДС-ийн гүйцэтгэх захирал В.Үнэнбат</p> <p>Гудамжны хаяг: УБ хот, БЗД, Энхтайваны өргөн чөлөө 16, Засгийн газрын 9А байр, ТЭДС 1-р давхрын 32 тоот өрөө</p> <p>Хот: Улаанбаатар хот</p> <p>Улс: Монгол улс</p> <p>Телефон утас: 261809,</p> <p><b>Албан бичиг солилцох Гүйцэтгэгчийн хаяг:</b></p> <p>Хэнд: [Хүний бүтэн нэр, боломжтой бол]</p> <p>Гудамжны хаяг: [Гудамны хаяг, дугаар]</p> <p>Давхар/ Өрөөний дугаар: [давхар өрөөний дугаар, боломжтой бол]</p> <p>Хот: [Хот, суурингийн нэр]</p> <p>ЗИП код: [шуудангийн зип код, боломжтой бол]</p> <p>Улс: [Улсын нэр]</p> <p>Телефон утас: [телефон утасны дугаар, улс хотын кодтой нь хамт]</p> <p>Факсын дугаар: [факсын дугаар, улс хотын кодтой нь хамт]</p> <p>Электрон шуудангийн хаяг: [электрон шуудангийн хаяг, боломжтой бол]</p>
ГЕН 5.1	Монгол улсын хуулиар тайлбарлана.
ГЕН 6.1.3	Маргаан шийдвэрлэгчийн цагийн хөлс: <i>[Цагийн хөлсийг чөлөөтэй хөрвөх валютаар илэрхийлнэ.]</i>
ГЕН 6.1.4	Маргаан шийдвэрлэгчийг томилох байгууллага: <i>[Томилох байгууллага нь тухайн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, хөндлөнгийн бие даасан байгууллага байна.]</i>

ГЕН 8.1	Гүйцэтгэгч Байгууламжийн ажлыг Гэрээнд заасан гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхэлнэ.
ГЕН 8.2	2018-09-01-ны дотор дүгнэнэ.
ГЕН 13.3.1	Гүйцэтгэлийн баталгааны дүн нь гэрээний үнийн дүнгийн 5 хувь байх ёстой.
ГЕН 13.3.2	Гүйцэтгэлийн баталгаа нь жишиг маягтын дагуу байна
ГЕН 14	Гүйцэтгэгчтэй ажил гүйцэтгэх гэрээг байгуулснаас хойш ажлын 7 хоногт багтаан гэрээний үнийн дүнгийн 30 хувийн урьдчигнааг, ажлын гүйцэтгэл дундаа орж Барилга, хөгжлийн төвөөр хянагдан ажил хэвийн явагдаж буй тодорхойлолтыг үндэслэн 40 хувийг, үлдэгдэл төлбөр болох 30 хувийг ажлыг улсын комисст хүлээлгэн өгсөн актыг үндэслэн тус тус төлбөрийг шилжүүлнэ.
ГЕН 25.2.2	Баталгааны шалгалтыг Гэрээ амжилттай дуусгавар болсон өдрөөс хойш 14 хоногийн дотор гүйцэтгэнэ.
ГЕН 26.2	Алданги нь гэрээ хэтрүүлсэн долоо хоног тутамд тэг аравны таван /0,5/ хувь байна. Алдангийн дээд хэмжээ гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.
ГЕН 26.3	Хугацаанаас өмнө дуусгасны шагнал олгохгүй
ГЕН 24.3 ба 25.2	Гэрээний ерөнхий нөхцлийн 24-р зүйлд заасан хугацаанд журмын дагуу хэрэгжүүлнэ.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“Тариалан эрхлэлтийг дэмжих сан” ийн

Хангамж борлуулалтын хэлтсийн дарга

  
Б.Отгонбаяр

Хуулийн эрх зүйн хэлтсийн дарга

  
Т.Төгөлдөр

Санхүү бүртгэл, төлөвлөлтийн хэлтсийн дарга

  
Д.Энхмаа

Захиалагчийн хаяг:

Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, 3 дугаар Дулааны цахилгаан станцын баруун талд  
Утас: 77238888

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“МГБИ” ХХК-ийн захирал



Л.Баттүвшин

Гүйцэтгэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 216, 201 тоотод байрлах

Утас: 99142974

Капитрон банк: 3026049999